



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 03 дугаар сарын 09

№ 01/75 Д.УА-2018/8/СА ТТЗ

Мандалговь хот

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын Тусгай зориулалтын сангуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад Эрүүл мэндийн төвийн ахмадын сангаас тус байгууллагад харьяалалгүй иргэдэд хүндэтгэл үзүүлэн 500,000.00 / таван зуун мянга / төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ дахь заалтууд, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 3.3 /сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно/ дах заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НБ:

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Мөнхчимэг, нягтлан бодогч Т.Хүдэрчулуун нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН<sup>1</sup>:**

АУДИТОР *Т.М. Б.ГАНТУЯА*

**ЗӨВШӨӨРСӨН:**

ДАРГА *Б.М. МӨНХЧИМЭГ*

Б.МӨНХЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ *Т.Х. ХҮДЭРЧУЛУУН*

Т.ХҮДЭРЧУЛУУН

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.